

**ЦАГААНДЭЛГЭР СУМЫН 2018 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХШҮ-НИЙ ДҮНГЭЭР ӨГСӨН
ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2018.12.13

Хараат

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хэрэгжилт	Хувь
Нэг. Төрийн захиргааны хүрээнд				
1.1	Салбарын дээд байгууллага, нутгийн зөвлөл, их дээд сургуулиудтай хамтран төсвийн байгууллагуудад байгаа дутагдалтай мэргэжилтнийг хангах, үр дүнтэй ажил зохион байгуулах	Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдана.	Суманд судалгаагаар 108 мэргэжилтэй боловсон хүчин, 42 оюутан байна. мөн сумын хэмжээнд дутагдалтай байгаа боловсон хүчний судалгааг улирал тутам гаргаж ажилласан. ЗДТГ-т 2018 онд 4, ЕБС-д 6, цэцэрлэг, соёлын төвд тус бүр 1, ЭМТ-д 4 боловсон хүчин дутагдалтай байснаас ЗДТГ-т 1, ЕБС-д 4, цэцэрлэгт 1, ЭМТ-д 3 орон тоог нөхөж ажилласан байна. Төрийн албаны салбар зөвлөлд 4 ажлын байрны захиалгыг хүргүүлж 3 ажлын байрны зарыг мэдээллийн самбар болон цахим сүлжээгээр нийтэд зарласан байна. Төрийн албаны хэвийн ажиллагааг хангахын тулд төрийн сангийн мэргэжилтэн, байгаль орчны байцаагчийн ажлыг түр хавсруулан ажиллуулж байна.	100
1.2	Төсвийн байгууллагуудын төрийн албан хаагчийн сургалтын болон ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг улирал 3Г-ын 89-р тогтоолын 10-р хавсралтын дагуу гаргаж дүгнэж нэгтгэх	Хөтөлбөр хэрэгжиж албан хаагчдын нийгмийн асуудал шийдэгдэнэ	Байгууллага тус бүр “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан баталж, жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгаж ажилласан. Цэцэрлэгээс эрхлэгч УБ хотод 2 удаа, аймаг бүсийн сургалтанд 9 удаа, багш нар 4 удаа аймгийн төвд сургалтанд хамрагдсан. Ажлын байрны дотоод сургалтыг 6 удаа явуулж багш ажилчид 100% хамрагдсан. СӨБ-ийн багшийн ангид эчнээгээр туслах багш Б.Өлзийжаргал, сантехникийн мэргэжил олгох сургалтанд жижүүр Э.Дорждавгыг хамруулж мэргэжлийн үнэмлэхтэй болгож суралцах хугацааны цалинг 50-иар олгож дэмжиж ажиллалаа. ЕБС, СӨБ-ийн багш нар боловсролын чиглэлээр зохион байгуулсан бүх төрлийн сургалт семинарт 100% хамрагдсан. ЭМТ-ийн эмч, албан хаагчид болон ЗДТГ-ын албан хаагчид аймаг, орон нутгаас зохион явуулсан улс аймаг, бүсийн орон нутгийн дотоодын сургалтуудад хөтөлбөр, удирдамжийн дагуу хамрагдсан. Тухайлбал ЗДТГ-аас 1 мэргэжилтнийг ХААИС-д эчнээгээр, ЭМТ-өөс 1 сувилагчийг вакцинатор сувилагчийн 3 сарын курст, 1 сувилагчийг Дорноговь аймаг дахь АШУИС-д лаборантаар, дүн бүртгэгчийг Улаанбаатар хотод архив, бичиг хэргийн 1 сарын сургалтанд соёлын төвөөс 1 ажилтныг СУИС-ийн соёлын сургуульд номын санчийн эчнээ ангид 1 ажилтныг нийгмийн ажилтнаар суралцуулж мэргэшүүлэх тал дээр төрийн албан хаагчдыг дэмжин ажиллаж байна. Улаанбаатар хотод 3 удаагийн, аймгийн төвд болсон 15 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 28 албан хаагч хамрагдсан байна. Сумын эрх зүйн хөтөч багаас 2018 онд судлан сурталчлах хууль эрх зүйн актын төлөвлөгөөнд 21 хууль тогтоомжийг судлуулахаар	100

			төлөвлөсөн. Үүнээс 11 сарын эцсийн байдлаар 14 хууль тогтоомжийг төрийн албан хаагчдад танилцуулж давхардсан тоогоор 208, төлөвлөгөөнөөс гадна 9 удаагийн мэдээлэл сургалтанд давхардсан тоогоор 216 иргэд, төрийн албан хаагч хамрагдсан. УИХ, ЗГ-аас баталсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагчдын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож мөрдөж ажиллаж байна. Оны эхэнд байгууллагын орон тоо, цалинг сар баталсан. ЗГ-ын 2018 оны 264-р тогтоол гарсантай холбогдуулан албан хаагчдын цалинг тогтоолын дагуу шинэчлэн баталж холбогдох нэмэгдэл хөлсийг олголоо. Байгууллагын дотоод журмыг үндэслэн 1-р улиралд Тамгын газрын албан хаагчдын 2018 оны ээлжийн амралтын хуваарийг гарган бүх албан хаагчийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлсэн. Ажилтан албан хаагчдын ажлын цагийг бүртгэн цахим бүртгэл болон бүртгэлийн дэвтрийг үндэслэн цагийн баланс гарган цалинг бодож сар бүр тогтоосон хугацаанд олгосон. Албан хаагчдад чөлөөний хуудсаар чөлөө олгож ажилласан. Албан хаагчдын амьдрах нөхцлийн сайжруулахад анхаарч багш нарын орон сууцанд 2 байрыг нийтийн халаалтанд холбож 2 сая төгрөгийг зарцуулсан. Шинээр гэр барьсан 2 албан хаагчид 310000 төг, 4 албан хаагчийн шинэ төрсөн 4 хүүхдэд 400000 төг, ар гэрийн гачигдал гарсан 7 албан хаагчид 460000 төг, 2 албан хаагчид УБ хотод эмчилгээ оношилгоонд явахад 3 албан хаагчид 135000 төг, 3 албан хаагчийг эмнэлэгт хэвтэхэд 90000 төгрөгийг тэтгэмж тусламж үзүүлсэн байна. Компьютерийн техник хэрэгслийн ашиглалтанд хяналт тавин компьютер техник хэрэгсэл, интернэтийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна. Энэ онд Тамгын газрын үйл ажиллагаанд нийт 20 компьютер, 15 принтер ашиглагдаж байна. Техник хэрэгслийг шинэчлэх засварлахад ЗДТГ-аас 4 сая төгрөг, Соёлын төв 1400000 төг, цэцэрлэг гарган шийдвэрлэлээ. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжид 2 багшид 6948000 төгрөг олгосон байна.	
1.3	Зөрчилтэй томилгоог арилгах	Томилгооны зөрчил арилна.	Зөрчилтэй томилгоотой 2 албан хаагч байснаас төрийн албаны шалгалтанд тэнцэж нөөцөд бүртгэгдсэн Ж.Чулуунтогтохыг төрийн сангийн мэргэжилтнээр томилж зөрчлийг арилгасан. МЭҮТ-ийн мэргэжилтэн Ц.Ундрахбаяр зөрчилтэй томилгоотой байна. Ажлын байрыг зарлахаар аймгийн ТАСЗ-д материалыг хүргүүлсэн. Ц.Ундрахбаяр нь тусгай дунд боловсролтой ба бакалаврын боловсрол эзэмшихээр ХААИС-д эчнээгээр суралцаж байгаа бөгөөд 2019 оны хавар төгсөх юм.	100
1.4	Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль болон ЗГ-ын 89-р тогтоолын 11-р хавсралтад заасан үйл ажиллагааны ил тод, хүний нөөцийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн	Үйл ажиллагаа ил тод, нээлттэй байж иргэд мэдээллээр хангагдана.	Байгууллагын үйл ажиллагааны болон хүний нөөцийн ил тод байдлыг ЗГ-ын 89-р тогтоолд заасан чиглэлийн дагуу мэдээллийн самбар, цахимаар мэдээлж ил тод байдлыг ханган ажиллалаа. Бүх төсвийн байгууллагууд Мэдээллийн ил тод байдал мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан мэдээллүүдийг ил тод мэдээлэх ажлын	100

	мэдээлийг бүрэн гүйцэд тогтмол тавьж хэвших		хүрээнд мэдээллийн самбартай болж мэдээллийг тухай бүр ил тод байршуулж ажилладаг.	
1.5	Иргэдээс санал хүсэлт авдаг нээлттэй утсыг иргэдэд сурталчлах, орон нутагт болж байгаа шинэлэг ажлын үйл явдлын мэдээллийг цахим хуудас, групп хаягуудаар мэдээлэх	Иргэд мэдээллээр хангагдана.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтнуудад хандаж ирүүлсэн санал, өргөдөл, гомдлын бүртгэн авч холбогдох ажилтанд өгч шийдвэрлүүлэн хуулийн хугацаанд хариуг өгч ажиллаж хэвшсэн. Төрийн байгууллага, багийн Засаг дарга нар, албан хаагчдад ирүүлсэн СӨГХ-ийг улирал тутам ЗДТГ-ын бичиг хэргийн ажилтан нэгтгэн аймгийн ЗДТГ-т мэдээлдэг. Засаг даргын Тамгын газрын СӨГомдол хүлээн авах утас 89643553, ЭМТ-д 89826055 нээлттэй утаснуудыг ажиллуулж байна. Албан байгууллага, албан хаагч нарт 2018 онд иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдол, ирсэнийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд хяналтын картаар хяналт тавьж, улирал бүрийн эцэст СӨГ-ийн мэдээг нэгтгэн тайланг холбогдох байгууллагад цахимаар болон цаасаар хугацаанд нь хүргүүлж ажилласан. 2018 оны 11 сарын эцсийн байдлаар нийт 335 санал хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, иргэдэд хариуг цаасаар болон утсаар, биеэр уулзаж хариуг өгч ажиллалаа. 7 хоног бүр шинэлэг ажлын мэдээг нэгтгэн аймгийн ЗДТГ-ын ХМОНА-д хүргүүлсэн. Сум орон нутагт зохион байгуулагдсан, хийж хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг аймгийн цахим хуудас болон Цагаандэлгэрийн мэдээ группт тухай бүр нь оруулж ажилласан.	100
1.6	7 хоногийн мэдээ явуулах ажлыг тогтмолжуулах, чанартай мэдээлэл явуулах	Ажлын үр дүн дээшилж мэдээллээр хангагдана.	Сум орон нутагт зохион байгуулсан үйл ажиллагааг Цагаандэлгэрийн мэдээ фейсбүүк групп, сумын мэдээ, аймгийн цахим хуудсанд байршуулж ажилласан. Удирдлагын зүгээс гарч буй захирамж, тушаалыг мэдээллийн самбарт тухай бүрт байршуулсан. 7 хоног бүрийн Баасан гарагт аймгийн ЗДТГ-ын ХМА-нд тухайн долоо хоногт болсон шинэлэг ажлын мэдээллийг явуулж ажилласан. 2018 онд 52 удаагийн мэдээ явуулахаас 43 удаагийн мэдээг хугацаанд явуулж 9 удаа тасалдуулж 82,6% тай байна.	90
1.7	ТАХ-ын сахилга хариуцлагыг дээшлүүлэхтэй холбогдон гарсан ЗГ-ын 2017 оны 01 тоот албан даалгавар, 2018 оны 32-р тогтоол болон хариуцлагын жилд сумын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж тайлагнах	Ажлын үр дүн дээшилнэ. ТАХ-ын сахилга хариуцлага сайжирна.	ЗДТГ-аас ЗГ-ын 2017 оны 01 тоот албан даалгаварыг хэрэгжүүлэх 16 заалт бүхий сумын төлөвлөгөөг Засаг даргаар батлуулан байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар тооцож дүгнэхэд хэрэгжилт 96,2%-тай байна. ЗГ-ын 32-р тогтоолыг хэрэгжүүлэх 36 заалт бүхий төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг тооцож ажиллахад хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 90%-тай байлаа. Албан байгууллагууд сумын төлөвлөгөөг хэрэгжүүлэх төлөвлөгөөг байгууллага тус бүр дээрээ гарган хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар дүгнэж ажилласан.	100
Хоёр. Нийгмийн бодлогын хүрээнд				
2.1	Эрүүл мэндийг дэмжих жилийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, жилийн ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	Ажлын үр дүн дээшилнэ.	Эрүүл мэндийг дэмжих жил"-ийн ажлын төлөвлөгөөг боловсруулж төлөвлөгөөнд 15 ажил тусгаж сумын Засаг даргаар батлуулан ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил болон жилийн эцсийн байдлаар холбогдох газарт нь хүргүүлж ажилласан.	70

2.2	Орон нутгийн хөгжлийн индексийг тооцох аргачлалын нийгмийн хүрээний 18 үзүүлэлтийн суурь судалгааг гаргаж, эерэг үзүүлэлтийг ахиулж сөрөг үзүүлэлтийг бууруулах зорилт тавин хэрэгжүүлж ажиллах	Нийгмийн хүрээний үзүүлэлтийн сайжирна.	Орон нутгийн хөгжлийн индексийг тооцох аргачлалын нийгмийн хүрээний 11 үзүүлэлтийн суурь судалгааг гаргасан.	70
2.3	ЕБС-ийн номын санг цахимжуулах ажлыг эрчимжүүлж фондын номоо 100% цахим бүртгэл оруулах	Ном цахим бүртгэл орно.	Дундговь аймгийн Төв номын сангаас сургуулийн номын сангуудын компьютерт цахим номын сангийн monbiblio праграммыг суулгасан. Мөн номын санч нарт сургалт зохион байгуулсан. Номын сангийн номнуудыг нэг бүрчилсэн бүртгэлд бүртгэж программдаа 100 ном оруулаад байна. Номын санг цахимжуулах ажил одоогоор 50%-тай явж байна.	50
2.4	ЗДТГ-ын дэргэдэх биеийн тамир спортын орон тооны бус зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх	Ажлын үр дүн дээшилнэ	Сумын Засаг даргын 2018 оны 7 сарын 19 ны өдрийн А/62 тоот захирамжийн дагуу сумын биеийн тамир спортын орон тооны бус зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Монгол Улсын Ерөнхий Сайдын ивээл дор зохион байгуулагдаж буй “Иргэдийн спортын наадам”-ын сумын аварга шалгаруулах спортын наадмыг 2018 оны 10 сарын 04-ний өдөр олс таталт, гар бөмбөг, ойрын зайн кросс гүйлт, сагсан бөмбөг, хөл бөмбөг гэсэн 5 төрлөөр зохион байгуулж 120 гаруй иргэд хамрагдсан. Шалгарсан тамирчид 10 сарын 05-07 ны хооронд Дундговь аймагт зохион байгуулагдсан аймгийн шигшээ наадамд гар бөмбөгийн төрөлд амжилттай оролцсон.	90
2.5	Өрх бүрийг угийн бичигжүүлэх ажлыг эрчимжүүлж сумын нийт өрхийн 50-аас дээш хувийг угийн бичигтэй болгох	Өрх бүр угийн бичигтэй болно.	Цагаандэлгэр сум нь 388 өрх, 1047 хүн амтайгаас 162 өрх угийн бичгээ хөтөлж байна. Жилийн эцсийн байдлаар угийн бичиг хөтлөх сургалтыг 5 удаа 254 иргэнд зохион байгуулж, гарын авлагыг 4 удаа 180 гаруй иргэнд тарааж танилцуулсан байна. Мөн төрийн албан хаагчдын дунд “Өрх бүр угийн бичгээ хөтөлцгөөе” уралдааныг зохион байгуулж нийт 22 өрх шинээр угийн бичгээ хөтөлсөн байна. “Уут отог боржигинчууд” овогтны “Мөнгөн ургийн баяр” 2018 оны 08-р сарын 18-19-нд Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын 4-р багийн нутаг “Цавчирын сүүл толгой” хэмээх газар болж 400 гаруй хүн оролцсон томоохон арга хэмжээ боллоо. Өвөг Балдан, эмэг Чулуун нараас үүсэлтэй 120 гаруй өрхийн 500-аад хүн болж өссөн түүхийг бичсэн ном бүтээж бүх өрхөд гардуулах ажлыг хийсэн байна. Монгол төрийн угийн бичиг хөтлөх бодлогыг хэрэгжүүлэхэд 120 гаруй өрх оролцсоны дотор манай сумаас 36 өрх хувь нэмрээ оруулж иргэний үүргээ биелүүлж угийн бичгээ хөтөлсөн байна. 2018 онд шинээр 58 өрх угийн бичгээ хөтөлсөн байна. Сумын хэмжээнд угийн бичиг хөтлөлт 42.8%-тай явж байна. 2017 онтой харьцуувал 15%-иар өссөн байна.	100
2.6	Морин хуур, уртын дууны сургалтыг хүүхэд, насанд хүрэгчдэд дунд адилхан зохион байгуулж хамтлаг байгуулах	Ажлын үр дүн дээшилнэ	Насанд хүрэгчдын дунд уртын дууны дугуйланг 1 удаа зохион байгуулж 79 иргэнд “Уяхан замбуу тивийн наран”, “Энх мэндийн баяр” дууг зааж сургасан байна. Сурагчдын дунд уртын дууны	90

			дугуйланг 2 удаа зохион байгуулж 86 сурагчийг хамруулж “Энхмэндийн баяр”, “Хөөрхөн халиун” дууг зааж сургасан байна.	
2.7	Жендерийн эрх тэгш байдлын салбар хорооны үйл ажиллагааг эрчимжүүлж хуулийн хэрэгжүүлж ажиллах	Ажлын үр дүн дээшилнэ	Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх сумын салбар хорооны төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. 2018 оны 5 сарын 9, 10-нд Улаанбаатар хотод болсон “Жендерийн тэгш байдал- Орон нутгийн хөгжилд сэдэвт сургалтанд нийгмийн бодлогын мэргэжилтэн хамрагдсан. 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 80%-тай хэрэгжсэн байна. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэрт байдлын тайланг гарган хугацаанд нь Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. Судалгаанд 82 төрийн албан хаагч хамрагдсан. 2018 оны 10 сарын 24 –нд хуулийн мэдээллийн цагаар “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулиар сургалт зохион байгуулж сургалтанд нийт 30 төрийн албан хаагч, иргэд хамрагдлаа.	90
2.8	Эрүү мэндийн болон сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж шинэ тутам гарсан хууль тогтоомжуудыг тухай бүх иргэдэд сурталчилж байх	Хууль хэрэгжиж, иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилнэ.	2018 оны байдлаар шинээр сайн дурын даатгалд 15 иргэн гэрээ байгуулж нийтдээ 125 иргэн даатгалд хамрагдаж байна. ЭМД-д 155 иргэн хамрагдсан байна. НД-ын хуулийн талаар сургалт сурталчилгааг хийж ажилласан. 4 багийн иргэдийн нийтийн хурал болон өдөрлөгөөр мэдээлэл хийсэн. 2018 оны 9 сарын 21 өдөр Нийгмийн даатгалын “Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулсан. 2018 оны 11 сарын 29,30-ны хооронд 4-р багийн засаг дарга Мягмардоржтой хамтран нийт 20 өрхөөр орж иргэдийг даатгалдаа хамрагдахыг уриалан мэдээлэл хийсэн.	100
2.9	ХБИ-ийг нийгэмшүүлэх, оролцоог хангах, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж төрөл бүрийн арга хэмжээг тэдний дунд зохион байгуулах	ХБИ-ийг нийгэм дэх оролцоо нэмэгдэж орлоготой болно.	"Хандлагыг өөрчилж-хамдтаа хөгжье" аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулга уулзалтад багуудын төлөөлөл болгож 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулсан. Чуулганд оролцсон иргэд өөрсдийн хийсэн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гаргаж зарж борлуулсан. Цаашид сумандаа ХБИ-ийн дунд төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулж тэдгээрийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллахаар төлөвлөж байна.	70
2.10	Байнгын болон түр ажлын байрыг нэмэгдүүлэх, зорилтот өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд санаачилгатай ажиллах үр дүнд хүрэх	Иргэд ажлын байраар хангагдаж орлого нэмэгдэнэ.	Байнгын болон түр ажлын байрыг нэмэгдүүлэхийн тулд ажилгүй иргэдийг ажилгүйдлийн бүртгэлд бүрэн хамруулж байнгын ажлын байранд 20, түр ажлын байранд 3 иргэнийг зуучилсан. Жижиг зээлийн төсөлд хамрагдсан иргэд түр ажлын байранд 2 иргэнийг хамруулсан. Зорилтот өрхийн амьжиргааг дээшлүүлэх тал дээр анхааран ажиллаж ажилгүйдэлд бүртгэн олгогч нартай уулзсан. Монгол ви ти нет төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж зорилтот 6 өрхийн 26 гишүүнд өвөлжилтөд зориулж 1680.000 төгрөгний буцалтгүй тусламж үзүүлсэн.	100
2.11	Хэдний бодлогын зөвлөл байгуулж жилийн төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж ажиллах	Ажлын үр дүн дээшилнэ.	Сумын Засаг даргын 2018 оны 7 сарын 19 –ний өдрийн А/61 тоот захирамжаар хэлний бодлогын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, жилийн ажлын төлөвлөгөөнд 5 ажил төлөвлөж төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж	70

			байна. Хэлний бодлогын зөвлөлөөс төрийн байгууллагуудад монгол хэлний зөв бичих дүрмийн сургалт явуулж эхэлсэн ба одоогоор ЭМТ, ЗДТГ, жижиг байгууллагуудын нийт 30 хүнд сургалт хийгдээд байна. Мөн хууль мэдээллийн цагаар “Монгол хэлний тухай хууль”-и-р мэдээлэл хийж Монгол хэлний зөв биёих дүрмээр тестийн шалгалт авах зэрэг ажлуудыг зохион байгуулсан.	
2.12	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиудыг сурталчлах үйл ажиллагааг эрчимжүүлэх	Хууль хэрэгжиж, иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилнэ.	ГХУСАЗСЗөвлөлтэй хамтран ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-и-р хуулийн мэдээллийн цагаар 2 удаа сургалт зохион байгуулж 40 төрийн албан хаагч 25 хүүхэд хамрагдсан. 2018 ны 3 сарын 9,10-нд болсон “Таван эрдэнэ-2” малчдын зөвлөгөөний үеэр “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” тухай хуулиар сургалт хийж, багийн дарга нар хөдөөгийн малчин өрхөөр явж цаг үеийн ажил байдалтай танилцаж мэдээлэл хүргэхээр явахтай холбогдуулж тус хуулиар гарын авлага хийж хөдөөгийн малчин 120 гаруй өрхөд хүргэсэн. Сумын залуучуудын бүлгэмийг сумын Засаг даргын 2017 оны 11 сарын 22 ны өдрийн А/56 тоот захирамжаар 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. 15-34 насны залуучуудын судалгааг 4 багаас нэгтгэж судалгаанд 15-34 насны 300 залуучууд хамрагдсан. “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль”-и-р хуулийн мэдээллийн цагаар сургалт зохион байгуулж нийт 25 төрийн албан хаагч иргэд хамрагдлаа. Аймгийн ЗДТГ, ГБХЗХГ-аас зохион байгуулж “Бидний аав-бидний ирээдүй” аавуудын анхдугаар чуулганд 22-39 насны 9 аав оролцсон. Мөн 2018 оны 12 сарын 1-нд Дундговь аймагт болсон залуучуудын бүлгэмийн гишүүдийг чадавхижуулах сургалтанд бүлгэмийн зөвлөлийн 4 гишүүн хамрагдаж ирсэн. Хүн амын тооллогоор малчин өрхөөр явж байгаа ажлын хэсгийн гишүүдэд залуучуудын хөгжлийн төвийн мэдээлэл болон, залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн гол үндсэн заалтуудаар 60 ширхэг мэдээлэл гарын авлага бэлтгэж 15-34 насны залуучуудад тараалаа.	100
2.13	Боловсролын чиглэлээр хэрэгжиж буй “Боловсрол хөгжил”, “Математик”, “Үндэсний бичиг” зэрэг аймгийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцох	Ажлын үр дүн дээшилнэ.	ЕБСургуулиас аймгийн Засаг даргын 2011 оны 12 дугаар сарын 28 ны өдрийн А/635 тоот захирамжийн дагуу “Математик” хөтөлбөрийн 5 зорилтоос 4 зорилт биелэгдсэн буюу 80%, “Үндэсний бичиг” хөтөлбөр 4 зорилт хэрэгжиж ажлын үзүүлэлт 90%, “Боловсрол хөгжил” хөтөлбөрийн 5 зорилт 95%-ийн биелэлттэй хэрэгжсэн байна.	90
Гурав. Санхүү, төрийн сангийн хүрээнд:				
3.1	Төсвийн орлогын төлөвлөгөөг төрөл тус бүрд жигд ханган биелүүлэх	Орлогын төлөвлөгөө биелнэ.	Татварын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд анхаарч татвар төлөгч 15 ААН, 7 байгууллага, 56 иргэнд давхардсан тоогоор 38 ширхэг нэхэмжлэх, 143 ширхэг мэдэгдэх хуудас, 16 ширхэг албан шаардлага өгч ажилласан. Мөн Сүмбэр Орд ХХК-иас хог хаягдлын хураамжид 100,0 төгрөг, ус рашаан ашигласны төлбөрт 116,0 төгрөг, Хөрс автосервис ХХК-ны салбараас хогны төлбөрт 10,0 төгрөг, НӨАТ суутган төлөгч, Одда тайж ХХК-иас түгээмэл	90

			тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, хогны төлбөр төлүүлснээр татварын бааз суурь нэмэгдэж байна. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлт дараах байдлаар биелэсэн байна. 2018 оны 12 сарын 01-ний байдлаар авч үзэхэд үйл ажиллагааны орлого буюу /ИОТТХ/ 5991,0 төгрөгөөс 4145,3 төвлөрч 69 хувьтай, хадгаламжийн хүүгийн орлого 4940,0 төгрөгөөс 4964,0 төвлөрч 100 хувьтай, бууны татвар 1084,8 төгрөгнөөс 934,0 орж 86 хувьтай, улсын тэмдэгтийн хураамж 1140.0 төгрөгнөөс 1439,6 орж 126 хувьтай, хог хаягдлын хураамж 1134,4 төгрөгөөс 644 орж 57 хувьтай, түгээмэл тархац 266.9 төгрөгөөс 0 төг орж 0 хувьтай, ангийн орлого 19200,0 төгрөг төвлөрч, хүү торгуулийн орлого 1266,7 төгрөгнөөс 2101,6 орж 166 хувьтай, төсвийн өөрийн орлого 70.0 төгрөг орохоос 0 орж 0 хувьтай, бусад орлого 42,9 төгрөгнөөс 23,4 орж 55 хувьтай, нийт 207 хувийн гүйцэтгэлтэй татварын орлогын төлөвлөгөө биелэн ажилласан байна. Төлөвлөгөө тасарсан орлогууд болох төсвийн өөрийн орлого, түгээмэл тархац, хог хаягдлын хураамжийн орлогууд нь 2018 оны 12 сард биелэх боломжтой байна.	
3.2	Сум хөгжүүлэн сангийн өр авлагыг хугацаанд нь барагдуулах	Өр авлага барагдана.	Сум хөгжүүлэх сангаас зээл авч үйл ажиллагаа явуулж байгаа 15 иргэн байн. Үүнээс 2013 онд СХС-ын зээлд 1 иргэн , 2014 онд 3 иргэн, 2015 онд 6 иргэн, 2016 онд 5 иргэн тус тус хамрагдан үйл ажиллагаа явуулж байна. Зээлийн хэрэгжилтийг авч үзвэл одоогоор сум хөгжүүлэх санд 15 иргэний үндсэн зээлд 38.879.712 төгрөг, зээлийн хүү 5.039.046 төгрөг бүгд 43.918.758 төгрөг төвлөрүүлэн ажиллалаа. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны зардалд шинэ программ суулгасны төлбөр 750.000 төгрөг, бичиг хэргийн зардалд 90.000 төгрөг, шуудан холбооны зардалд 120.000 төгрөг, шатах тослох материалын зардалд 350.000 төгрөг, сургалт сурталчилгааны зардалд 100.000 төгрөг бүгд 1.410.000 төгрөг зарцуулан сум хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл 133.112.520.50 төгрөг байна. Зээл хугацаандаа төлөгдөөгүйн улмаас 11 иргэний үндсэн зээл 36.947.688 төгрөг, зээлийн хүү 2.197.832 төгрөг буюу 39.145.520 төгрөг төвлөрөөгүй алдагдалтай явж байна. Зээлийн хугацаа дуусаагүй байгаа боловч хугацаандаа зээл, зээлийн хүүгээ бүрэн төлж барагдуулсан 2 иргэн байна. Мөн зээл төлөгдөх хугацаа болоогүй 10.616.334 төгрөг 5 иргэний гар дээр эргэлтэнд ашиглагдаж байна. 2017 онд аймгийн санхүүгийн дотоод аудитын алба, аудитын газар, Аймгийн Хөдөө аж ахуйн газар зэрэг байгууллагаас шалгалт хийгдэн зээл төлөх талаар хугацаатай мэдэгдэл өгч байсан. Энэ хугацаанд иргэн ААН-д хугацаатай мэдэгдэл 5 удаа өгснөөс гадна өөрийн биеээр уулзаж зээл төлөх талаар шаардах утсаар сар бүр ярьж ажиллаж байлаа. Мөн сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт тавих, зээл хэлэлцэх орон тооны бус зөвлөлийг 1 удаа хуралдуулан ИТХ-д зээл олгох дээд хязгаар, төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгод	100

			нийцүүлэн суманд хэрэгжүүлэх төслүүдийн тэргүүлэх чиглэлийг гарган хурлаар хэлэлцүүлэх санал хүргэж ажилласан байна.	
Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд:				
4.1	Орон нутгийн тусгай хамгаалалтанд авах газар нутгийг ИТХ-аар батлуулах	Тусгай хамгаалалттай газар нутгийн тоо нэмэгдэнэ.	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд орон нутгийн тусгай хамгаалалтанд авах газрыг тусгаж өгсөн. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө 2018.12.18-ны ИТХ-ын хуралдаанаар батлагдах юм.	70
4.2	Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу чанартай зохион байгуулах /ОНХС, УТХО/-аар хийгдсэн ажлыг зохих дүрэм журамд нийцүүлэн хүлээн авч, холбогдох данс бүртгэлд тусгах	Хуулийн хэрэгжилт хангагдана.	2018 оын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 13 ажил арга хэмжээний 9 ажлыг хууль журмын дагуу зохион байгуулж ажилласан. Улсын төсөв болон ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлыг данс бүртгэлд тусгаж ажилласан.	90
4.3	Монгол мал, Тэмээ хөтөлбөрийн хүрээнд үр дүнтэй ажлуудыг зохион байгуулж хэрэгжилтийг хангах	Хөтөлбөр хэрэгжиж ажлын үр дүн дээшилнэ.	Монгол мал хөтөлбөрийн зорилтуудын дагуу мал ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх ажил хийгдэж хонь 188, ямаа 295 нийт 483 мал ээмэгжүүлсэн. 2018 оны ноосны урамшуулалд 156 малчин, мал бүхий өрхийн хонины ноос 49859,9 кг, тэмээний ноос 849,3 кг нийт 50709,2 кг ноосыг урамшуулалд хамруулахаар материалыг аймгийн ХХААГ-т хүргүүлсэн. Сумын хэмжээнд 2016 оны жилийн эцсээр 607 тэмээ тоолуулж байсан бол 2017 оны эцсээр 663 тэмээ тоолуулж 56 толгой тэмээгээр өссөн байна. Мөн 2017 онд ноосны урамшуулалд 180 кг тэмээний ноос урамшуулалд хамрагдсан бол энэ онд 849,3 кг тэмээний ноос урамшуулалд хамрагдахаар тушаагдсан байгаа нь өмнөх оноос тэмээнээс авч байгаа ашиг шим нэмэгдсэн байна.	100
4.4	Хүлэмж, зоорийн ашиглалтыг сайжруулах, төмс хүнсний ногоо, малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэх, иргэд, ААН-ийн тариалалтын судалгааг гаргаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах	Иргэдийн орлого нэмэгдэж ажлын үр дүн дээшилнэ.	7 өрх нэгдэн 1 нөхөрлөл болон зохион байгуулагдан сургуульд байрлах хүлэмжийг ашиглан нарийн ногоо, огурци тариалах, ил талбайд төмс хүнсний ногоо, сонгиго зэрэг тариалалт хийж Инвест ко-оп Монгол төслөөс 800000 төгрөгийн дэмжлэг авч үйл ажиллалгаа явуулж ирсэн. Мөн тухайн төслөөс сургагч багш сургалт явуулан зөвлөн туслах үйл ажиллагаа явуулж байсан. Дундговь аймгийн ХХААГ-аас 100000 төгрөгийн үнэтэй үрийн дэмжлэг үзүүлэн сумын төвийн иргэдэд үр олгон тариалалт явуулахад сумын хэмжээнд 1 бүлэг, 14 иргэн 05 га-д төмс хүнсний ногоо, 0014 га-д манжин, 0133 га-д лууван, 0013 га-д сонгино, 00264 га-д өргөст хэмх тариалсан. Намар ургац хураалтаар сумын хэмжээнд 15 өрх төмс, хүнсний ногоо хураан авч ажиласнаас, төмс 600кг, лууван 100 кг, хүрэн манжин 30 кг, улаан лооль 40 кг, чинжүү 40 кг, сонгино 90 кг, өргөст хэмх 550 кг, шийгуа 30 кг-ийг хураан авсан дүн мэдээтэй байна. Уг мэдээ мэдээллийг Хүнс хөдөө аж ахуйн газарт мэдээлсэн байна.	100
4.5	2011-2017 онуудад олгосон хугацаа хэтэрсэн зээлийн өр барагдуулах арга хэмжээг зохион байгуулах үр дүнгийн	Өр авлага барагдана. Иргэд	2017 онд Аймгийн Аудитын газраас 2011-2017 онд олгосон зээлийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж хугацаа хэтрэлттэй байгаа 2 ААН, 22 иргэнд 75134256 төгрөгийн хэтрэлт үүссэн гэсэн дүгнэлт гаргаж хугацаатай мэдэгдэл өгсөн. Өгсөн мэдэгдлийн дагуу иргэн	100

	талаарх мэдээ тайланг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх	мэдээллээр хангагдана.	ААН-тэй хамтран ажилласны дүнд 2 ААН, 16 иргэний зээлийн хэтрэлт 56.047.091 төгрөгийг тухайн санд төвлөрүүлэн 2 иргэнийг аймгийн сум дундын шүүхээр шийдвэрлүүлэхээр материалыг өгч ажиллалаа. Одоо 4 иргэний 7.852.917 төгрөгийн үлдэгдэлтэй буюу зээл төлөлт 89.5 хувьтай явж байна. Тайланг мэдээллийн самбарт ил тод байршуулж ажилласан.	
4.6	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн ажлын үр дүнг сайжруулах	Ажлын үр дүн дээшилнэ.	Суманд үйл ажиллагаа явуулдаг “Буянт мал сүрэг”, “Цаст-Ундарга” мал эмнэлгүүдтэй 2018 онд хамтран ажиллах сумын Засаг дарга, Мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга, хувийн мал эмнэлгийн хооронд гурвалсан гэрээг байгууллаа. Мөн мал эмнэлгүүд үйлчилгээ үзүүлэх малчидтай гэрээ байгуулсан. Малын гоц халдварт Шүлхий өвчин гарсны улмаас 4650 үхэрт давтан тарилтаар 2 удаа, 362 тэмээ, эрүүл бүсийн 11288 хонь, 8810 ямаа нийт 25110 малын урьдчилан сэргийлэх вакцинд хамруулсан байна. Шөвөг яраас сэргийлэх вакциныг 79 өрхийн хурга 7078, ишиг 11344 нийт 18422 төлд хийгээд байна. Цусан халдвартын вакцинд 7934 бог, дотрын халдварт хордлогын вакцинд 8096 бог мал, сахуугаас сэргийлэх вакцин 669 унага, Дуут хавдараас сэргийлэх вакцин 200 үхэр, галзуугаас сэргийлэх вакцин 200 үхэр, шүлхийн вакцин 3326 үхэрт, бруцеллёзын вакцинд тугал 231, хурга, ишиг 31672 төл хамруулсан байна. Туулгалтанд хонь 8750, ямаа 3636, угаалга 13580 мал угаалганд хамруулсан.	100
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ				90,3

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР